213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,081,962.19
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	227,719,310.29
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	227,719,310.29
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	227,719,310.29
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	208,447.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	208,447.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, зөв бодлого, оновчтой шийдэл, тогтвортой хөгжлийг ханган иргэд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамж, стандартын шаардлагад нийцсэн нийгэм эдийн засгийн эрчимтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Өндөрширээт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Сумын санхүүгийн албанаас мөнгөн хөрөнгө, бараа материал, төсвийн зардалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар төлөвлөсөн ажлыг хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид эрсдэлд суурилсан дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт орлого 3,387,188.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 50,808.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 38,106.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,236,874.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 63,554.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 38,397.2 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 47,665.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн орлого 253,148.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 893,265.1 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 700,501.6 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 78,186.2 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 1,086,999.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 12,516.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 227,719.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 81,681.3 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлого 135,905.8 мянган төгрөг, нийт 3,469,926.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Өндөрширээт сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 99,160.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 8,847.5 мянган төгрөг, нийт 108,007.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 249,545.2 мянган төгрөг, татварын бус орлого 3,603.1 мянган төгрөг, нийт 253,148.3 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 145,140.8 мянган төгрөг буюу 234.4 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд 2021 онд малын тоо толгойн татварыг сумын ИТХ тогтоож баталсантай холбоотой 87,899.8 мянган төгрөг, ан агнуурын нөөц ашигласны орлого 60,464.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 22,390.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,510,308.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 1,532,698.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба тайлант онд хөрөнгө хасагдаагүй байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 440,295.2 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 131,374.1 мянган төгрөг, нийт 571,669.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 488,903.0 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 120,101.5 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 282,870.0 мянган төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 11.9 мянган төгрөг нийт 402,983.4 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 249,417.0 мянган төгрөг буюу 61,9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 120,094.4 мянган төгрөг буюу 28,9 хувийг ЭМТ, 25,971.9 мянган төгрөг буюу 6,4 хувийг Эргэлтийн эмийн сан, 7,500.0 мянган төгрөг буюу 1,9 хувийг ОНХС -ийн авлага эзэлж байна.

Байгууллагад төлөх 9,392.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 28,300.7 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 679.5 мянган төгрөг, нийт 38,372.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өрийн 28,074.0 мянган төгрөг буюу 73,2 хувийг ЭМТ-ийн өр эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 375,516.7 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 6,151.0 мянган төгрөг, нийт 381,667.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 350,445.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,993,476.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	137,762,064.6	381,667,720.7	243,905,656.0
Авлага	260,873,339.9	402,983,383.2	142,110,043.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	267,679,592.9	350,445,863.73	82,766,270.8
Нөөцийн бараа /сурах бичиг/	-	-	-
Үндсэн хөрөнгө	4,665,201,286.0	5,993,476,193.2	1,328,274,907.2
Нийт хөрөнгө	5,331,516,283.5	7,128,573,160.8	1,797,056,877.3
Өр төлбөр	2,216,162.0	38,372,220.9	36,156,058.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,329,300,121.5	7,090,200,939.9	1,760,900,818.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,331,516,283.5	7,128,573,160.8	1,797,056,877.3

Бараа материалын дансны үлдэгдэл 350,445.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 82,766.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, тусгай зориулалтын материал, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,993,476.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 1,328,274.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн үндсэн хөрөнгө нь үнэ төлбөргүй хүлээн авсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЭМТ-ийн барилга 1,297,621.6 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т цэцэрлэгт хүрээлэн, худаг 71,638.9 мянган төгрөг, Соёлын төвд дээврийн засвар 58,791.8 мянган төгрөг, цэцэрлэгт цэвэр усны байгууламж 52,464.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,090,200.9 мянган төгрөг болж 1,760,900.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,966,264.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өндөрширээт сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 9 дүгээр тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 108,007.5 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 1,996,819.0 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,037,171.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 180,000.0 мянган төгрөгөөр, нийт 2,217,171.3 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 749,093.2 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 7 хөтөлбөр 20 арга хэмжээнд зориулан нийт 2,217,171.3 мянган төгрөг төлөвлөсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг нийт 2,210,505.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЕБС 5,915.6 мянган төгрөгөөр илүү, төсөвт газрын өөрийн орлого 750.0 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Нийт зардлын 1,079,833.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 826,234.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,553.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 110,549.8 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 180,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 1,792,298.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 8,282.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 102,200.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,902,780.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 48,077.6 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 80,112.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,902,780.7 мянган төгрөг буюу 86.0 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 227,510.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 203,246.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 11,172.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 13,081.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 208.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Өндөрширээт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, БНСБС-ийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 71,638.9 мянган төгрөгийн 2 залруулга, 1,422.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 29,483.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5,526.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж, ИТХ-д 1,263.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, СХС-д 84,722.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6,008.3 мянган төгрөгийн зөвлөмж, Соёлын төвд 849.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 625.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус өгөгдсөн байна.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл аудит ХХК аудит хийж, ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 873.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,281.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 601,929.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 1,463.0 мянган төгрөгийн 1

төлбөрийн акт, 426.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 146,804.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 6,460.0 мянган төгрөгийн 1 залруулга, 454.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,421.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 424,934.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эргэлтийн эмийн санд 28,125.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Өндөрширээт сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар тогтоолоор тодотгон баталсан 2,196,617.8 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 14,893.5 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс тусгай зориулалтын шилжүүлэг 14,637.9 мянган төгрөг, ЗДТГ 255.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ 653.6 мянган төгрөг, Соёлын төв 48.9 мянган төгрөг, ЭМТ 119.8 мянган төгрөг дутуу, ЕБС 367.5 мянган төгрөг, Цэцэрлэг 92.8 мянган төгрөг, ЗДТГ 116,035.1 мянган төгрөгөөр тус тус илүү зөрүүтэй байна. Орон нутгийн татварын орлогын тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэлд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг файл оруулж мэдээлсэн ч нээгдэхгүй, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй, аудитын тайлан дүгнэлтийг оруулсан ч нээгдэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 7 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 01/274 дугаар албан бичгээр ирүүлсэн ба СХС-ийн зөвлөмж бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг таслан зогсоосон эсэх болон ковидын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 152,585.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 119723.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,029.1 мянган төгрөгийн албан шаардлага, 8,833.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсөвт байгууллагуудын татварын өр, авлагын тодорхойлолтыг татварын цахим системээр гаргахад төсвийн нийт 6 байгууллагад 2,025.0 мянган төгрөг дутуу, 117,698.1 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй гэж тайлагнасан нь ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 22,320.2 мянган төгрөгөөр буюу 82.7 хувиар, галт зэвсэгийн албан татвар 34.0 мянган төгрөг буюу 0,2 хувиар, газрын төлбөр 969.7 мянган төгрөг буюу 22,6 хувиар, Төсөвт газрын өөрийн орлого 280.2 мянган төгрөг буюу 37,4 хувиар, хүү торгуулийн орлого 425.0 мянган төгрөг буюу 17,0 хувиар нийт 5 нэр төрөл нийт 33,134.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн

төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Аймгийн Татварын хэлтсийн мэдээ нь татварын улсын байцаагчийн аудитад ирүүлсэн мэдээгээр 253,148.1 мянган төгрөг бөгөөд Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 252,678.5 мянган төгрөг байгаа тул 795.2 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн, Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь орлогыг орлогын дансны хуулгатай тулган шалгахад үл ажиллагааны орлого 902.4 мянган төгрөгөөр, ТГӨО 469.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

1.2. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор сумын татварын орлого 99,160.0 мянган төгрөг, татварын бус орлого 8,847.5 мянган төгрөг, нийт 108,007.5 мянган төгрөгөөр баталсан. Орлогын гүйцэтгэлийн тайланд ТГӨО-ын батлагдсан төлөвлөгөө 750.0 мянган төгрөгийг, ТЗШ-ийн орлого сумын ИТХ-аас баталсан дүнгээс 5,915.6 мянган төгрөгөөр дутуу нэгтгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэхдээ сумын ИТХ-аас баталж ирүүлсэн тогтоолын тоо, дүн зөрүүтэй алдааг засуулж авах

бөгөөд тогтоол нь төлөвлөгөөнөөс зөрүүтэй байсан зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг файл оруулж мэдээлсэн ч нээгдэхгүй, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй, аудитын тайлан дүгнэлтийг оруулсан ч нээгдэхгүй зэрэг зөрчил гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн хэмнэлтийн тайлбар шалтгааныг ойлгомжтой мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Өндөрширээт сумын Засаг дарга	4	152,585.2	1	119,723.1			1	24,029.1	2	8,833.0	Зөрчилгүй
	ТТЗ-ийн дүн	4	152,585.2	1	119,723.1	-	-	1	24,029.1	2	8,833.0	
2	Өндөрширээт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	1,263.5	-	-	-	-	1	1,263.5	-	-	Түүвэр
3	Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар	5	102,544.8	2	71,638.9	1	1,422.6	2	29,483.3	-	-	Зөрчилгүй
8	Өндөр ширээт сумын Хүн эмнэлэг	6	434,270.2	1	6,460.0	2	454.4	1	2,421.5	2	424,934.3	Зөрчилгүй
9	Өндөрширээт сумын Соёлын төв	2	1,475.2	-	-	1	849.4	1	625.9	-	-	Түүвэр
10	Өндөр ширээт сумын Ерөнхий боловсролын сургууль	6	605,084.6	-	-	2	873.9	1	2,281.4	3	601,929.2	Зөрчилгүй
11	Өндөр ширээт сумын Хүүхдийн цэцэрлэг	4	148,693.5	-	-	1	1,463.0	1	426.4	2	146,804.1	Зөрчилгүй
	ТШЗ-ийн дүн	24	1,293,331.7	3	78,098.9	7	5,063.2	7	36,502.0	7	1,173,667.6	
4	Өндөрширээт сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	Түүвэр
5	Өндөрширээт сумын Сум хөгжүүлэх сан	2	90,730.5	-	-	-	-	1	84,722.2	1	6,008.3	Түүвэр
6	Өндөрширээт сумын БНСБС	-	-	-	-	-	-	-	-	-	-	Түүвэр
7	Өндөр ширээт сумын Эмийн эргэлтийн сан	2	28,125.1	-	-	-	-	2	28,125.1	-	-	Түүвэр
	ОНТС-ийн дүн	4	118,855.6	-	-	-	-	3	112,847.3	1	6,008.3	
	Нийт дүн	32	1,564,772.5	4	197,822.0	7	5,063.2	11	173,378.4	10	1,188,508.9	